

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2021 оны 3 сарын 20-ны өдөр

№ 21/01

Улаанбаатар хот

**Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК ( цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтыг тус тус удирдлага болгон Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 3 сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2020 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2021 оны 3 сарын 20-ны өдөр

№ 21/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
зарим гишүүдийг улируулан сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 болон 77.2 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 1 (нэг) жилээр сунгаж, улируулан сонгосугай.
  - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүн:
    - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
    - 1.1.2. Монгол Улсын иргэн Володьяа овогтой Баярсайхан
    - 1.1.3. Монгол Улсын иргэн Баянжаргал овогтой Дэлгэржаргал
    - 1.1.4. Монгол Улсын иргэн Нармандах овогтой Цэвэгмид
    - 1.1.5. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
    - 1.1.6. Монгол Улсын иргэн Цэвэгжав овогтой Одмаа
  - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн:
    - 1.2.1. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил
    - 1.2.2. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн
2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг улируулан сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргад даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2021 оны 3 сарын 20-ны өдөр

№ 21/03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дахь хэсэг, 79 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнээр Болд овогтой Өлзийбаярыг сонгосугай.
2. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Болд овогтой Өлзийбаярт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргад даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2021 оны 3 сарын 20-ны өдөр

№ 21/04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсвийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.11 дэх заалт, 2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсвийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

